



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2025 оны 02 сарын 18 өдөр

Дугаар A/63

Улаанбаатар хот

Арилжаанд оролцох эрхийг сэргээх тухай

Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1, "Монголын хөрөнгийн бирж" хувьцаат компанийн Дүрмийн 6 дугаар зүйлийн 6.9.3, "Гишүүнчлэлийн журам"-ын 5 дугаар зүйлийн 5.3.1 дэх заалтууд болон "Масдак ҮЦК" хязгаарлагдмал хариуцлагатай компанийн 2025 оны 02 сарын 11-ний өдрийн 1/21 тоот албан хүсэлтийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Гүйцэтгэх захирлын 2022 оны 09 дүгээр сарын 07-ны өдрийн А/96 дугаар тушаалаар арилжаанд оролцох эрхийг нь хязгаарласан "Масдак ҮЦК" ХХК нь гаргасан зөрчлөө арилгаж, үйлчилгээний хөлсөө төлсөн тул арилжаанд оролцох эрхийг 2025 оны 02 дугаар сарын 18-ны өдрөөс эхлэн сэргээсүгэй.
2. "Масдак ҮЦК" ХХК-ийн үнэт цаасны арилжааны программд нэвтрэх нэр, нууц үгийг сэргээхийг Үйл ажиллагааны газар (И.Жавхлан)-т үүрэг болгосугай.
3. Монгол Улсын үнэт цаасны зах зээлд мөрдөгдөж буй хууль тогтоомж, дүрэм, журам, заавар болон "Гишүүнчлэлийн гэрээ"-ээр хүлээсэн үүргээ тогтмол биелүүлж ажиллахыг "Масдак ҮЦК" ХХК (Ч.Нямдорж)-д даалгасугай.
4. Гүйцэтгэх захирлын 2022 оны 09 дүгээр сарын 07-ны өдрийн А/96 дугаар тушаалыг 2025 оны 02 дугаар сарын 18-ны өдрөөс эхлэн хүчингүй болгосугай.
5. Тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт, зохицуулалтын газар (А.Мөнхбаясгалан)-т, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод хяналтын алба (Ч.Эрдэнэболор)-нд тус тус даалгасугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Б.ДӨЛГӨӨН

1525030131